



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/215

Зуунмод сум

БНМАУ-ын баатар Д.Самдангийн
Нэрэмжит тэмцээний зардал гаргах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/50 дугаар тушаал, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион явуулдаг БНМАУ-ын баатар Д.Самдангийн нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байнгын байрлалд баталсан удирдамжийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд зохион явуулсугай.

2. Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулах аймгийн аварга шалгаруулах “Дөл” цогцолбор тэмцээний удирдамж зааврын дагуу, аюулгүй ажиллагааг ханган зохион явуулахыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч бригадын генерал (Т.Лодойдамба) Цэргийн штабын дарга дэд хурандаа (Т.Төмөрчөдөр)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн тасаг сурагчдын бэлтгэлийг хангаж 08 дугаар сард Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах “Дөл” цогцолбор тэмцээнд оролцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт даалгасугай.

4. Тэмцээнд шаардагдах зардал 1,952,400 (нэг сая есөн зуун тавин хоёр мянга дөрвөн зуу) төгрөгийг аймгийн төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д, шилэн дансанд байршуулахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б. Одончимэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 -р сарын 19 -ны өдрийн А/215-р захирамжийн 1 -р хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН АХЛАХ
АНГИЙН СУРАГЧ НАРЫН ДУНД УЛАМЖЛАЛ БОЛГОН ЯВУУЛДАГ
ЦЭРЭГ СПОРТЫН “ДӨЛ” ТЭМЦЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Байр	Шагнал	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Мөнгөн шагнал	Бүгд үнэ
1	1-р байр	Өргөмжлөл	1	15.000	500.000	515.000
2	2-р байр	Өргөмжлөл	1	15.000	300.000	315.000
3	3-р байр	Өргөмжлөл	1	15.000	200.000	215.000
4	Тусгай	Өргөмжлөл	1	15.000	100.000	115.000
5	Дасгалжуулагч багш /шилдэг/	Өргөмжлөл	1	15.000	100.000	115.000
6	Шилжин явах цом	-	1	120.000	-	120.000
7	Аннос	-	1м	12,000 6x2.5	-	158.400
8	Алт, мөнгө, хүрэл медаль		42ш	9500	-	399.000
Бүгд						1,952,400

ТӨСӨВЛӨСӨН:

ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА

ДЭД ХУРАНДАА

Т.ТӨМӨРЧӨДӨР

ХЯНАСАН:

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ

МЭРГЭЖИЛТЭН

Ч.ЦЭЦЭГСҮРЭН